



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/386

Улаанбаатар хот

Мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлэх
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.16, 12.17 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь;

1. Ерөнхий боловсролын сургалтын байгууллагад шаардлагатай мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч ажиллахыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус даалгасугай.

1.1. Мэргэжлийн багш хүрэлцээгүйн улмаас хичээл, сургалтын тасралтгүй байдал алдагдахад хүрсэн тохиолдолд тухайн сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер болон бусад багш мэргэжилтэй ажилтнаар мэргэжлийн дагуу долоо хоногт 6 хүртэл цагийн хичээл заах нөхцөлийг бүрдүүлж, сургалтын хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

1.2. Багш мэргэжлээр их, дээд сургуульд 3.2-оос дээш голч дүнтэй суралцаж байгаа төгсөх ангийн оюутныг ерөнхий боловсролын сургуульд тухайн мэргэжлийн багшийн сул орон тоонд дагалдан багшаар ажиллуулах.

2. Энэхүү тушаалын 1.1, 1.2-т заасны дагуу сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, хичээл заасан сургалтын менежер, бусад ажилтан, дагалдан багшид холбогдох хууль тогтоомжид заасан цалин, хөлсийг олгохыг ерөнхий боловсролын сургалтын байгууллагын захирал нарт даалгасугай.

3. Энэхүү тушаалын 1.1-д заасны дагуу ерөнхий боловсролын сургалтын байгууллагын захирлыг мэргэжлийн дагуу хичээл заах тохиолдолд хууль тогтоомжид заасан цалин хөлсийг тооцон олгох шийдвэр гарган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга нарт даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн зөвлөмж, удирдлагаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т даалгасугай.

14231 1798

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар /Л.Төгсбаяр/-т даалгасугай.

САЙД



Я. ЭНХ-АМГАЛАН